

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН
/ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭС/

2025.06.06

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилт от түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО: АЙМГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ							
1	Зорилт 1. “Эрх зүйн сургалт, сурталчилгаа, иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах” зорилтын хүрээнд:						
1.1	Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ажлыг орон нутагт зохион байгуулах, арга зүйгээр хангах	30.0	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	100	60	Бүх нийтэд эрх зүйн боловсрол олгох үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нутгийн удирдлагын ордон, Зэст багийн нэгдсэн байр, Захиргааны 4-р байруудад эрх зүйн хөтөч нарыг ажиллуулж, иргэд хууль зүйн туслалцаа мэдээлэл авахад шаардлагатай, техник тоног төхөөрөмж, гарын авлагаар бүрэн хангаж, иргэдэд зөвлөгөө, мэдээлэл, туслалцаа үзүүлэн ажиллаж байна. Эрх зүйн хөтөч нар тайлант хугацаанд 380 иргэнд хууль зүйн зөвлөгөө өгч, 10 сэдвээр 109 хуулийн постер, сторигор 43 зурагт хуудас бэлтгэж, 15 гарын авлага хийж иргэдэд тарааж, “Номин” телевизтэй хамтран “Хуулийн цаг” 13 удаагийн нэвтрүүлэг, богино хэмжээний видео 8, нийт 21 нэвтрүүлэг, видео бэлтгэж телевиз болон цахим хэлбэрээр иргэдэд сурталчилж ажилласан.	100
1.2	Эрх зүйн хөтөч ухуулагч нарыг удирдлага арга зүйгээр хангах, ажлын үр дүнг тооцох, чадавхижуулах ажлыг хэрэгжүүлэх	-	Сургалт сурталчилгааны ажилд иргэдийн хандалт	141280	80000	Хууль сурталчлах, иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх зөвлөгөө мэдээллээр хангах чиг үүрэг бүхий эрх зүйч мэргэжилтэй 5 эрх зүйн хөтчийг орон нутгийн төсвөөс цалинжуулж гэрээ байгуулан ажиллуулж байгаа бөгөөд хэлтсээс удирдлага, арга зүй, зохион байгуулалтаар ханган ажлын үр дүнг тооцож ажиллаж байна. Эрх зүйн хөтөч нар тайлант хугацаанд 5 сэдвээр 15 удаагийн сургалтыг 23 багийн иргэд болон төрийн албан хаагч нарыг хамруулан зохион байгуулж давхардсан тоогоор нийт 2495 орчим хүн хамрагдаж, 380 иргэнд хууль, эрх зүйн анхан шатны зөвлөгөө мэдээллийг үнэ төлбөргүй өгч ажилласан. Мөн 7035 3511-(2) дугаарын нээлттэй утсанд хандсан 22 иргэнд, цахим орчинд “Орхон хууль эрх зүйн хэлтэс” фэйсбүүк пэйж хуудсын чат мессэнжерт хандсан 47 иргэнд тухай бүр зөвлөгөө, мэдээлэл өгч	100

						ажилласан. Сургалт сурталчилгаа, хууль зүйн туслалцаа үзүүлэх арга хэмжээнд нийт давхардсан тоогоор 111530 хүн хамрагдсан.	
1.3	Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааг арга зүйн удирдлагаар хангаж, иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах	8.0	Өмгөөлөлийн үйлчилгээ болон зөвлөгөө өгсөн иргэдийн тоо	139	Төвд хандсан иргэдэд үйлчилгээ үзүүлсэн байна.	Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааг тогтворжуулах, төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх хууль зүйн туслалцааны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн төсөвт төвийн үйл ажиллагаанд шаардагдах 8 сая төгрөгийг тусган батлуулж, дэмжлэг үзүүлсэн. Төвийг Зэст багийн нэгдсэн байранд шинэ ажлын байраар хангаж иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлүүлэх, мөн ганцаарчлан уулзах өрөөг тохижуулан байрны урсгал зардал, утас болон интернетийн зардлыг ЗДТГ-аас бүрэн хариуцдаг. Хууль, эрх зүйн хэлтсийн даргаас өмгөөлөгчийн үйл ажиллагаа, санал хүсэлтийн талаарх мэдээллийг 7 хоног бүр авч, удирдлага арга зүйгээр ханган аймгийн ЗДТГ болон хууль, эрх зүйн хэлтсээс явуулж буй үйл ажиллагаанд хамруулан дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд 110 иргэнд эрх зүйн туслалцаа үзүүлж, зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан.	100
1.4	Хууль тогтоомжийн лавлагааны санг бүрдүүлж, иргэд байгууллагад лавлагаа мэдээллээр үйлчлэх ажлыг зохион байгуулах	-	- Санд шинээр бүртгэсэн актын тоо - Үйлчилгээ үзүүлсэн иргэдийн тоо	-987 -51	Шинээр гарсан актаар санг баяжуулж, лавлагаа мэдээллээр үйлчилсэн байна.	Хууль, эрх зүйн хэлтсийн хууль тогтоомжийн лавламжийн санд хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль, УИХ-ын тогтоол, Монгол улсын олон улсын гэрээ, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, Улсын дээд шүүхийн тогтоол, Засгийн газрын тогтоол, Сайдын тушаал, УИХ-аас томилогддог байгууллагын дарга, түүнтэй адилтгах албан тушаалтны шийдвэр, ЗГ-ын агентлагийн даргын тушаал, аймгийн ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж нийт 53989 хууль тогтоомжийн актыг гар болон цахим сандаа бүртгэн авч, "Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем" болон "Төрийн мэдээлэл", "Захиргааны хэм хэмжээний актын эмхтгэл" сэтгүүл, гар санг ашиглан иргэд, байгууллагад мэдээлэл, лавлагаагаар үйлчилж байна. Мөн мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор аймгийн Засаг даргын нийт 473 захирамжийг гарсан даруйд нь www.erdenet.mn сайтад байршуулсан. Лавлагааны санг нийт 549 эрх зүйн актаар шинээр баяжуулж, 37 актын 76 зүйл заалтад нэмэлт өөрчлөлтийг тусган лавлагаа, мэдээллээр үйлчлэх ажлын бэлэн байдлыг хангаж ажиллалаа. Лавлагааны сангаас хууль, Засгийн газрын тогтоол, Сайдын тушаал, ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамжаар нийт 17 байгууллага, иргэнд гар болон цахим сангаас лавлагаа мэдээллээр үйлчилсэн байна.	100
1.5	Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэх	-	Шийдвэрлэсэн өргөдөл гомдлын тоо	117	Өргөдөл гомдлыг хуулийн дагуу хугацаа	Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах төвийн 70353511 утсаар ирсэн 15, Засгийн газрын 1111 утсанд ирүүлсэн 8, бичгээр ирүүлсэн 2, нийт 52 өргөдөл гомдлыг хүлээн авч, хуулийн хугацаанд шийдвэрлэж хариуг өгсөн. Нийт ирсэн 25 өргөдөл гомдлын 88.0% буюу 22 өргөдлийг ажлын 5 хоногт багтаан шийдвэрлэж хариуг хүргүүлсэн. Шийдвэрлээгүй 3 өргөдөл хуулийн хугацаандаа байна.	100

					нд нь шуурхай шийдвэр лэсэн байна.		
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО: ЗАСАГ ДАРГА БОЛОН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, ИРГЭДЭД ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ, ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ							
2	Зорилт 2. “Нутгийн удирдлагын байгууллага, засаг дарга, бусад байгууллагад хууль зүйн туслалцаа үзүүлэх, зөвлөгөө мэдээллээр хангах” зорилтын хүрээнд:						
2.1	Аймгийн Засаг даргын шийдвэр болон аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр, дүрэм, журмын төсөл, захиргааны болон худалдан авах ажиллагааны гэрээний төслийг хянаж, санал дүгнэлт өгөх, хууль зүйд нийцүүлж гаргахад мэргэжлийн туслалцаа үзүүлэх, зөвлөгөө мэдээллээр хангах	-	Хянаж санал өгсөн төслийн тоо	987	шинээр батлагд ах актын төслийг хуульд нийцүүлж гаргасан туслалцаа үзүүлсэн байна.	Аймгийн Засаг даргаас аймаг, сумдын ИТХ-ын хуралдаанд оруулах 4 шийдвэр, төрийн байгууллагуудаас гаргаж буй 5 дүрэм журам, аймгийн Засаг даргаас гаргасан 473 захирамжийн хууль зүйн үндэслэлийг төслийн шатанд хянаж санал дүгнэлт өгч, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-тэй хамтран ажиллах гэрээ, “Ачит ихт” ХХК-тай хамтран ажиллах гэрээ, Булган аймагтай хамтран ажиллах гэрээ зэрэг орон нутагт үйл ажиллагаа явуулж буй томоохон аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан гэрээнүүд, улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар ажил гүйцэтгэх 110, бараа худалдан авах 32, үйлчилгээ үзүүлэх 6, аваарын зардлаар ажил гүйцэтгүүлэх 10, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах 28, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах 30, ажил гүйцэтгэх сунгалтын 15, нэмэлт ажил гүйцэтгэх 2 гэрээг тус тус хянан баталгаажуулж ажилласан. Нийт 236 гэрээг хянан баталгаажуулсан байна.	100
2.2	Баян-Өндөр, Жаргалант сумдын Засаг даргын 2024 онд гаргасан шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг хянах, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах	-	- хянасан шийдвэрийн тоо - зөрчлийг арилгуулсан шийдвэрийн тоо	-576 -37	Шийдвэрийг хянаж зөрчлийг арилгуулсан байна.	2024 онд Баян-Өндөр сумын Засаг даргын А/01-А/412, Б/01-Б/16, Жаргалант сумын Засаг даргын А/01-А/558, Б/01-Б/47 дугаар захирамж, нийт 985 захирамжийн хууль зүйн үндэслэл, эрх зүйн зүйн сургалт сурталчилгаа, авлигын эсрэг үйл ажиллагаа, мэдээллийн ил тод байдлыг хангах ажлын хүрээнд зохион байгуулж буй ажил, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, дүнг Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, байгууллагуудад зөвлөмж хүргүүлсэн. Сумдын Засаг дарга нарыг хууль зүйн туслалцаа, мэдээллээр хангаж, шүүхийн шатанд байгаа хэргүүдийн шийдвэрлэлттэй танилцаж, тухай бүрт нь холбогдох зөвлөгөө, зөвлөмж өгч хамтран ажиллаж байна.	100
2.3	Жаргалант сумын нотариатын үүрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд мэргэжлийн туслалцаа үзүүлэх, арга зүйгээр хангах	-	Нотариатын үйл ажиллагаа хуульд нийцсэн байх	-	Удирдлага арга зүйгээр хангаж ажилла	Жаргалант суманд нотариатын үүрэг гүйцэтгэгч ажилладаг бөгөөд удирдлага, арга зүйгээр хангах ажлыг зохион байгуулж, ХЗДХЯ-аас цахимаар зохион байгуулсан 1 удаагийн сургалтад хамруулсан. Холбогдох тайлан мэдээ, судалгааг хугацаанд нь хүргүүлж хяналт тавьж ажиллаж байна. Мөн Орхон аймагт үйл ажиллагаа явуулж буй Нотариатын салбар Зөвлөлийн дарга болон нотариатч нартай 2 удаагийн уулзалт зохион	100

					сан байна.	байгуулж, иргэдэд үзүүлж буй үйлчилгээний шуурхай байдлыг хангах иргэдийг чирэгдүүлэхгүй байх талаар санал солилцож, тодорхой шийдэл гаргаж хамтарч ажиллаж байна.	
2.4	Аймгийн Засаг дарга болон ЗДТГ-ын даргын шийдвэртэй холбогдуулж иргэд, байгууллагаас гаргасан нэхэмжлэлийг шүүхээр хянан шийдвэрлэхэд болон шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд төлөөлөх, үр дүнг танилцуулах	5.0	төлөөлсөн хэргийн тоо	36	Шүүхэд төлөөлөх ажлыг хэрэгжүүлсэн байна.	Аймгийн Засаг дарга, ЗДТГ-ыг төлөөлөн шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тогтмол оролцож байна. Тайлант хугацаанд нийт 31 хэрэгт итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож байгаагаас аймгийн Засаг дарга болон Засаг даргын Тамгын газрын нэхэмжлэлтэй 6 хэрэг байна. 12 хэргийг шүүхээр эцэслэн шийдвэрлүүлсэн. Өнөөдрийн байдлаар ажиллагаанд 19 хэрэг байгаагаас хэргүүдийг төрлөөр нь авч үзвэл: Иргэний хэрэг – 9, Захиргааны хэрэг – 10 тус тус байна.	100
2.5	Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг ХЗДХЯ-нд хянуулж улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг зохион байгуулах	-	хянуулсан шийдвэрийн тоо	-	шинээр батлагдсан шийдвэрийг хянуулж бүртгүүлсэн байна.	Аймгийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/100 дугаар захирамжаар Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлд 35.2-д заасан амьтны хүрээлэн ажиллуулах журам, мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсийн хил хязгаарыг тогтоох, хориглосон бүсэд нэвтэрсэн малыг түр хадгалах, түүнтэй холбогдон гарсан зардлыг нөхөн төлүүлэх журам, оршуулгын үйл ажиллагаа эрхлэх, зохион байгуулах, оршуулгын үйл ажиллагааны жишиг үнэ, зөвшөөрөлтэй оршуулгын газар болон зөвшөөрөлгүй газар оршуулсан шарилыг шилжүүлэх журам, нийтийн эзэмшлийн гудамж, талбайн гэрэлтүүлэг, кабелийн шугамын ашиглалт, үйлчилгээний журам, инженерийн бэлтгэл ажлын төлөвлөлт, ашиглалт, хамгаалалтын журам нийт 5 журмын төслийг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлөөр хэлэлцүүлсэн. Хурлын зөвлөлөөс Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 132 дугаар тогтоолоор бүх төрлийн үйлчилгээний төлбөр, татвар, хураамжийн хувь хэмжээ тогтоохыг хориглосон тул тодорхойгүй хугацаагаар дээрх журмын төслүүдийг хурлын хуралдаанаар оруулахаас татгалзсан.	100
2.6	Удирдлагаас өгсөн үүрэг, даалгавар, чиглэлийн дагуу байгууллага, аж ахуйн нэгжүүдэд тодорхой хуулийн хэрэгжилтийн байдалд хяналт шалгалт явуулах, хууль зүйн зөвлөгөө мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах	-	Хяналт шалгалт зохион байгуулах	-	Хяналт шалгалтыг явуулж, зөвлөгөө мэдээллээр хангасан байна.	Тайлант хугацаанд улсын байцаагч нар хариуцсан чиглэлийн хүрээнд дараах төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: Зам, тээврийн яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн баталсан 04/06 дугаартай удирдамжийн дагуу их эрсдэлтэй үнэлэгдсэн "Орхон АЗЗА" ТӨХК, "Жавхлан харгуй" ХХК, "Шилдэг зам" ХХК-ны нийт 5 объектод 04.2.3-Авто замын барилга, их болон ээлжит засвар, шинэчлэлтийн ажлыг шалгах хяналтын хуудас, 04.2.4-Авто замын арчлалт хамгаалалт, урсгал засварын ажлыг шалгах хяналтын хуудсаар төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийсэн. Хяналт шалгалтаар 65	100

						зөрчил илрүүлж, 59 зөрчлийг бүрэн арилгасан байна. Зөрчил арилгалтын хувь 91.3. Шалгалтын явцад 5 албан шаардлага үйлдсэн. Дунд эрсдэлтэй 3, бага эрсдэлтэй 2. Үр дүн: Авто замын чиглэлээр мөрдөгдөж буй хууль сахин мөрдөлтийн дундаж 90,6 үнэлэгдсэн. Эрсдэл үүсэх магадлал 6,3% байна. Эрчим хүчний яамны Салбарын хяналтын газрын даргын баталсан 11/03 дугаартай удирдамжийн хүрээнд эрсдлийн шалгуур үзүүлэлтээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нийт 9 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийж илэрсэн зөрчлийг арилгуулах 52 заалттай 4 албан шаардлага, 6 заалттай 1 зөвлөмж, улсын ахлах байцаагчийн 3 дүгнэлт үйлдэн тус тус хүргүүлж, 2 аж ахуйн нэгжид нийт 2 сая төгрөгийн шийтгэвэр ногдуулан барагдууллаа. Хяналт шалгалтын мэдээллийг шилэн хяналтын нэгдсэн системд бүртгэсэн болно. Мэдээлэл, харилцаа холбооны чиглэлээр нийт 5 объектыг төлөвлөгөөт хяналт шалгалтад хамруулахаас 5 хамрагдсан. Хамрагдалт 100 хувь. Нийт 5 объект шалгалтанд хамруулснаас 3 объектын үйл ажиллагаа зогссон. Шалгалтаар их, дунд эрсдэлтэй объектийн эрсдэлийн түвшинг 100 хувиар буюу 2 объектийн эрсдэлийг бууруулсан. Хяналтын хуудсаар 13 зөрчил илрүүлж, газар дээр нь 9 зөрчлийг арилгуулж, 4 заалт бүхий 2 албан шаардлага үйлдсэн. Үр дүн: Харилцаа холбооны чиглэлээр мөрдөгдөж буй хууль сахин мөрдөлтийн дундаж 85,6 үнэлэгдсэн. Эрсдэл үүсэх магадлал 14,3% байна.	
3	Зорилт-3: Эмэгтэйчүүд, хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах түр хамгаалах байр байгуулж, хуульд заасны дагуу мэдээллээр хангана.						
3.1	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журам сахиулах ажлыг зохион байгуулах, нэгдсэн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах	20.0	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	50%	55 хувь	Аймгийн Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөр, Хууль зүй, дотоод хэргийн сайдаас аймгийн Засаг даргатай 2025 онд хамтран ажиллах гэрээ, аймгийн ГХУСАЗСЗ-ийн 2025 оны төлөвлөгөө зэргийг үндэслэн аймгийн Засаг даргаар 2025.01.24-ний өдөр “Аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө” батлуулан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Тус төлөвлөгөөг аймгийн төрийн байгууллагуудад хүргүүлж тухайн байгууллага бүрийг дотооддоо тусдаа төлөвлөгөө гарган ажиллах талаар чиглэл өгч, хэрэгжилтийг хангуулан, биелэлтийг хагас жил тутам авч, хяналт тавин ажиллаж байгаа болно. Аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний эхний хагас жилийн тайланг нэгтгэн аймгийн ГХУСАЗСЗ-д танилцуулсан. 2025 оны эхний хагас жилд нийт 29 байгууллагаас төлөвлөгөөний хүрээнд хийсэн ажлын биелэлтээ ирүүлсэн болно.	100
3.2	Мансууруулах эм, сэтгэцэт нөлөөт бодисыг	18.0	- урьдчила	- 82 ААН	- 82ААН	Тайлант хугацаанд “Анзаар-2” нэгдсэн арга хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 17-18-ны өдрүүдэд Орхон аймгийн хэмжээнд зохион байгуулсан ба	100

	хууль бусаар ашиглах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх		н сэргийлэх ажлын хамралт - мансууруулах төрлийн ургамлын устгах	-130 га	- 150 га	үүнд төрийн бүхий л байгууллагуудын ажилтан, албан хаагчид оролцсон. "Устгал-2025" нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах төлөвлөгөөг боловсруулан, шаардагдах төсөв санхүүг Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Засаг даргын тамгын газраас шийдвэрлүүлэн бэлтгэл ажлыг хангасан. Орхон аймгийн хэмжээнд мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг худалдах зөвшөөрөл авсан 11, эм ханган нийлүүлэх 1, энгийн үйлчилгээтэй 62 нийт 74 эмийн санд хяналт шалгалтын ажлыг 2025 оны 05-р сарын 06-аас 09-ний өдрийн хооронд хийж гүйцэтгэсэн. 2025 оны эхний хагас жилийн байдлаар хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг 2 гэмт хэрэг бүртгэгдэж холбогдох мөрдөн шалгах ажиллагааг явуулж байна. ШШГГ-аас мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэргээр шийтгэгдсэн 5 хоригдлыг харуул хамгаалалтын анхаарал татсан хоригдлын судалгаанд авч, харуул хамгаалалтын алба хаагч нарт үүрэг өгч үзлэг нэгжлэгийг төлөөлөгч нарыг байлцуулан хийлгэж хэвшсэн ба уг гэмт хэрэгт ял шийтгэгдсэн хоригдлын ажлын байр, өрөө, бие эд зүйлд үзлэг нэгжлэг хийхэд илэрсэн зөрчилгүй.	
3.3	"Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх	10.0	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	82.3	90 хувь	Аймгийн Замын цагдаагийн тасгаас сургуулийн өмнөх боловсролын байгууллагын дунд жил бүр зохион байгуулдаг "Замын хөдөлгөөний цагаан толгой 2025" тэмцээнийг 16 цэцэрлэгийн 160 хүүхдүүдийн дунд амжилттай зохион байгуулсан. Тэмцээнийг зохион байгуулахад шаардлагатай 10 сая төгрөгийг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс шийдвэрлэсэн. Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчлөөс урьдчилан сэргийлж Гэрээт цагдаагийн хэлтсийн Замын цагдаагийн хэсгийн алба хаагчидтай хамтран "Уусан бол бүү жолоод" нэгдсэн хяналт шалгалтыг 2 удаа зохион явуулсан. Мөн аймгийн хэмжээнд хөдөлгөөний ачаалал өглөө 07.00 цагаас 08.30 цаг, өдөр 12.00 цагаас 14.00 цаг, оройн 17.00 цагаас 18.30 цагийн хооронд хөдөлгөөний ачаалал нэмэгдэж ачаалал их үүсдэг Захиргааны 4 замын уулзвар, Чандмань төвийн уулзвар, Холбооны уулзваруудад биет зохицуулалтыг хийж, мөн гэр хорооллын замд осол хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хяналт шалгалтаар ажиллах алба хаагчдыг томилон ажиллаж байна. Хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зөрчил 7.2 хувь, Авто зам дээр үйлдэгдсэн зөрчил 6.6 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.	100
3.4	Архинд донтох эмгэгтэй хүнд үзүүлэх эмчилгээ, үйлчилгээг сайжруулах, албадан эмчилгээнд хамруулах ажлыг зохион	6.0	Албадан эмчилгээнд хамрагдс	19	25	Албадан эмчилгээний зардалд 6.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тусган батлуулж, Баян-Өндөр, Жаргалант сумын багуудын нутаг дэвсгэрт архины хамааралтай, орон гэргүй согтуурах, мансуурах донтой 55 иргэнийг эрүүл мэндийн нэгдсэн үзлэг шинжилгээнд хамруулан эрүүл мэндээрээ тэнцсэн 34 иргэнийг албадан эмчилгээнд хамруулах зорилгоор "Согтуурах,	100

	байгуулахад дэмжлэг үзүүлэх		ан иргэдийн тоо			мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай” хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр гаргуулж Орхон аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Хорих 437 дугаар ангид 34 иргэнийг хүлээлгэн өгсөн. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас зарласан гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрх, иргэнд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх тендерт шалгарсан “ХАМТДАА ТЭМҮҮЛЭХ ГЭРЭЛТ ИРЭЭДҮЙ” НҮТББ 2025 оны 1 дүгээр сарын 1-нээс 2 дугаар 15-ны өдрүүдэд гэр оронгүй тэнэмэл, архи, согтууруулах ундааны хамааралтай иргэдийг хооллох, хоноглох үйлчилгээнд хамруулж 27.6 сая төгрөг зарцуулсан. Тус үйлчилгээ хүйтний улиралд хэрэгждэг тул 11 сараас үргэлжлүүлэн хэрэгжүүлээр төлөвлөж байна. Тайлант хугацаанд дээрх үйлчилгээнд хамрагдсан 4 иргэн “Хамтдаа тэмүүлэх гэрэлт ирээдүй” ТББ-ын мод үржүүлгийн газар ажиллаж, 2 иргэн барилга дээр түр ажил хийж байна.	
3.5	Гэрч, хохирогчийг хамгаалах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх	5.0	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	90	100	Аймгийн Цагдаагийн газраас эрүүгийн хэргийн гэрч, хохирогч болсон иргэдэд тусламж үйлчилгээ үзүүлэх, хамгаалалтын арга хэмжээг зохион байгуулах, болзошгүй эрсдэл, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх таслан зогсоох, мэдээ мэдээллээр хангах зорилгоор гэрч хохирогчийн эрх, үүрэг хамгаалалтын арга хэмжээнд хэрхэн хамрагдах талаарх мэдээллийг агуулсан зурагт хуудас, хялбаршуулсан гарын авлага эмхтгэл зэргийг бэлтгэн хэвлүүлж тараах, гэрч, хохирогчийг хамгаалах чиглэлээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлэг, сурталчилгаа явуулах тогтмол цаг, булантай болох, түүгээр дамжуулан үнэн, зөв мэдээллийг олон нийтэд хүргэх ажлын хүрээнд орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй хамтран ажиллах, Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль тогтоомжийн дагуу Орхон аймаг Баян-Өндөр суманд үйл ажиллагаа явуулж буй Ерөнхий боловсролын сургуулиуд болон Цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүнд сургалт зохион байгуулах, бэлгийн болон гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах, гэрч, хохирогч нарт хууль зүйн зөвлөгөө болон сэтгэл зүйн зөвлөгөөг өгөх, хамгаалуулагч этгээдэд заналхийлэгч этгээд нь дахин аюул заналхийлэл үзүүлсэн эсэхэд хяналт тавих ажлыг зохион байгуулах зэрэг ажлуудын зардлыг Орхон аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран гэрч хохирогчийг хамгаалах ажлын зардлаас шийдвэрлүүлэн ажиллаж хэвшсэн. Орхон аймагт Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэрч хохирогчийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Хүүхдийн инээмсэглэлтэй аав” ТББ, “Хос холбоо” ТББ, “Аминчхан яриа” ТББ болон Орхон аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай	100

						хамтран гэрч, хохирогчид нийгмийн болон эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх, холбон зуучлах ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна. Энэ оны эхний хагас жилийн байдлаар тус Цагдаагийн газраас хамгаалалтад авагдсан гэрч хохирогч байхгүй байна.	
3.6	Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажлыг идэвхжүүлж, насанд хүрээгүй иргэдийн эрх ашгийг хамгаалах ажилд чиг үүргийн хүрээнд оролцох	10.0	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	90	100	Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааны зардалд орон нутгийн төсвөөс 15.0 сая төгрөгийг батлуулж, эхний хагас жилийн байдлаар гэмт хэрэгт холбогдсон 4, гэмт хэргийн хохирогч болсон 17 хүүхдэд сэтгэл зүйн болон өмгөөллийн үйлчилгээ үзүүлсэн байна. Тайлангийн хугацаанд 25 хүүхдийг 7 удаагийн /давхардсан тоогоор 100 хүүхэд/ зан үйлийн сургалтад хамруулан, хүүхэд бүрт хувийн хэрэг нээн ажиллаж байна. Гэмт хэрэг, зөрчилд холбогдсон хүүхдүүдэд сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр 2025 оны сүүлийн хагас жилийн хугацаанд хамтран ажиллахаар гэр бүл судлаач, сэтгэл зүйч иргэдтэй хамтран ажиллах гэрээг байгуулсан. Бага насны хүүхдийг зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ерөнхий боловсролын 1-р сургуультай хамтран явган хүний гарцаар гарахдаа шар дарцаг хэрэглэж хэвшье уриан дор хүүхэд багачуудад мэдээлэл өгсөн. Сургуулийн өмнөх боловсролын 2, ерөнхий боловсролын 3 сургууль, цэцэрлэгийн нийт 152 хүүхэд, багачуудад зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулсан. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны 2025 оны ажлын төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, төлөвлөгөөний хэрэгжилт 65 хувьтай үнэлэгдсэн. Тайлант хугацаанд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хүүхэд оролцсон гэмт хэрэг 41.7 хувиар буурсан байна.	100
3.7	Орон нутагт Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах, Үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй албадад чиглэл өгч, сургалт зохион байгуулах	10.0	Хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажилласан байна.	-	Тайлан мэдээг хугацаанд хүргүүлсэн байна.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 73 дугаар зарлигаар "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам"-ын батлагдсан. Тус журмын дагуу 2025 оны хагас жилийн тайлан мэдээг нэгтгэн боловсруулж 2025 оны 07 дугаар сарын 10-ны дотор хүргүүлэхээр бэлтгэж байна. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 14/03 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн түвшинд үндэсний аюулгүй байдлыг хангах хөтөлбөр"-ийг батлуулан хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам шинэчлэгдсэнтэй холбогдуулан ҮАБЗ-ийн ажлын албанаас орон нутагт ҮАБ-ыг хангах бодлого хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах чиглэл ирсэн. Үүнтэй холбогдуулан 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр хөтөлбөрийн хэрэгжилтийн явц байдлыг аймгийн ИТХ-ын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж 03 дугаар улирлын ИТХ-ын хуралдаанаар шинэчлэн	100

						батлуулахаар төлөвлөсөн. Хөтөлбөрийг байнгын ажиллагаатай ажлын хэсгийн хурлаар хэлэлцэж шинэчлэн боловсруулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	
3.8	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	8.0	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	90	100	“Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг” НҮТББ-д хэрэглэгчийн эрхийг хамгаалах үйл ажиллагааг хэвийн явуулахад жил бүр орон нутгийн төсвөөс жил бүр 8.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн ажилладаг. Үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн бүтээгдэхүүний шошго, сав баглаа боодолд олон улсын хэмжээнд нийтлэг мөрдөж буй барааны тэмдэг код, сав баглаа боодлын шошго шаардлага хангаж байгаа эсэх, хэрэглэгчдэд өгөх мэдээлэл үнэн зөв эсэх, тодорхой хаяг шошгогүй эсвэл хадагалах хугацааг заагаагүй бүтээгдэхүүн худалдаалж байгаа эсэхэд хяналт тавьж Хүнс, хөдөө аж ахуйн газар, Стандарт хэмжил зүйн хэлтэстэй хамтран ажиллаж, 9 аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүний шошгыг шинэчлүүлж, зураасан кодтой болгох шаардлагыг тавин ажилласан. Хүнсний сав баглаа боодлын шошгоны талаархи мэдээ мэдээллийг хэрэглэгчдэд өгч, 2 удаагийн сургалт зохион байгуулж, сургалтад 18 аж ахуйн нэгж хамрагдсан. Тайлант хугацаанд иргэд, хэрэглэгчдээс ирүүлсэн 9 гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, хариуг хүргүүлэн ажилласан.	100
3.9	Хүний эрхийг хангах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах	10.0	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	90	100	Хүний эрхийн Үндэсний комисстой хамтран 2025 оны 05 дугаар сарын 06-07-ны өдрүүдэд “Хүний эрх хамгаалагчийг хамгаалах механизмыг таниулах үйл ажиллагааны талаар сургалт хэлэлцүүлгийг 2 өдөр зохион байгуулсан. Тус сургалт хэлэлцүүлэгт ЕБС-ийн 250 сурагч, Их дээд сургууль, коллежийн 28 оюутан, 110 иргэн, захиргааны байгууллагын 34 төрийн албан хаагч, төрийн тусгай чиг үүрэгтэй 26 албан хаагч, ТББ-ын төлөөлөл болон үйлдвэрчний эвлэлийн хорооны 40 гишүүд нийт 448 хүн тус сургалтад хамрагдсан байна. Мөн Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж, байгууллагуудад хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд илтэд халдахаар байршилд хяналтын камер байрлуулсан байдал болон хурууны хээний бүртгэл зэргийг хянаж шалгах ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна.	100
4	Зорилт 4. “Архивын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх” зорилтын хүрээнд:						
4.1	Архивын баримтыг цахим хэлбэрт оруулах ажлыг хэрэгжүүлэх	-	Цахимжуулсан баримтын хувь	30	35	“Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутгийн төсөвт 57.0 сая төгрөгийг тусган батлуулж, цахимжуулалт хариуцсан 2 ажилтныг гэрээгээр ажиллуулж байна. Архивын ерөнхий газарт хэрэгжүүлж буй төслийн хүрээнд төрийн архивын CAMS системийг шинээр ашиглалтад оруулахтай холбоотойгоор улсын хэмжээнд цахим системд баримт шинээр холбох ажил түр зогссон.	100

						2025 оны 06 дугаар сарын 01-нээс эхлэн дээрх шинээр ашиглалтад орж буй архивын CAMS системд хөмрөгийн бүртгэлийг үүсгэх ажлыг эхлүүлж, 153 хөмрөг үүсгэгчийн хөмрөгийн хэрэг болон дансны бүрдлийн мэдээллийг бүртгэх ажил хийгдээд байна.	
4.2	Архивын сан хөмрөгийн нөхөн бүрдүүлэлтийн төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллах	-	нөхөн бүрдүүлсэн баримтын тоо	292 ХН	Ирүүлсэн баримтын тоогоор	Төрийн архивын сан хөмрөгийг 2023-2027 онд бүрдүүлэх үндсэн болон боломжит эх үүсвэрийн жагсаалтын дагуу сан хөмрөгийг 2024 онд нөхөн бүрдүүлэх ажлын хуваарийг гарган батлуулсан. Хуваарийн дагуу нийт 14 байгууллагаас баримтыг хүлээн авахаар төлөвлөж, хуваарийг хөмрөг үүсгэгч байгууллагуудад хүргүүлсэн. Хуваарийн дагуу хөмрөг үүсгэгч байгууллагуудын баримтыг хүлээн авах ажил 3 дугаар улирлаас хийгдэж эхэлнэ. Аймгийн ЗДТГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу хөмрөг үүсгэгч 28 захиргааны байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтөд хяналт шалгалт хийсэн	100
4.3	Иргэд байгууллагад архивын баримтын лавлагаа мэдээллээр үйлчлэх ажлыг зохион байгуулах	-	үйлчилгээ үзүүлсэн иргэдийн тоо	711	Хүсэлт гаргасан иргэдэд үйлчилгээ үзүүлсэн байна.	Лавлагаа, хуулбар олгох, баримтыг ашиглуулах хүсэлтийн дагуу нийт 273 иргэн, хуулийн этгээдэд архивын баримтын лавлагаа гаргаж олгох үйлчилгээг үзүүлсэн байна. Үүнээс: хөдөлмөр эрхлэлтийн 233 цалингийн 12, бусад 3, малын А данс 9 олгосон байна. Мөн архивын сан хөмрөгт шилжиж ирээгүй болон байхгүй тодорхойлолтыг 140 иргэнд олгосон байна. e-archives.gov.mn сайт болон онлайнаар ирүүлсэн хүсэлтийн дагуу баримтын лавлагааг цаг тухайд нь шийдвэрлэж, бусад аймаг хот руу захиалга өгсөн 1249 иргэний лавлагааг тухай бүрт нь иргэнд хүлээлгэн өгч ажиллалаа.	100
4.4	Архивын байнга хадгалагдах баримтуудыг сэргээн засварлах ажлыг зохион байгуулах	5.0	Сэргээн засварласан баримтын тоо	-	Шаардлагатай баримтуудыг сэргээн засварласан байна.	Тайлангийн хугацаанд 1 хөмрөгийн 1 дансны 267 хадгаламжийн нэгжийн 32000 хуудас баримтыг иж бүрэн нягтлан шалгаж, үүнээс баримт нягтлан шалгах явцад нийт 125 хуудас баримтыг сэлбэн засч, 267 хадгаламжийн нэгжийг хавтаслаж, хамгаалалтын хайрцгийг сольсон.	100
5	Зорилт 5. “Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах” зорилтын хүрээнд:						
5.1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөх, хэрэгжилтийг тооцох, тайлагнах ажлыг хэрэгжүүлэх	15.0	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	94	96	Аймгийн 2025 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө зэрэг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх бодлого төлөвлөлтийн баримт бичгүүдэд авлигын эрсдлийг бууруулах, төрийн үйлчилгээг үе шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлэх, төрийн албан хаагчдын ёс зүй, хариуцлагыг сайжруулах, худалдан авах ажиллагааны болон төсвийн ил тод байдлыг хангах, төсвийн сахилга батыг дээшлүүлэх, шийдвэр гаргах үйл ажиллагаа болон төсвийн зарцуулалтад иргэдийн оролцоо хяналтыг нэмэгдүүлэх зэрэг зорилтуудыг тусгаж хэрэгжилтийг тооцож ажиллаж байна.	90

						Мөн “Аймгийн хэмжээнд авлигын эсрэг хууль тогтоомж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-г аймгийн Засаг даргаар батлуулан АТГ болон хэрэгжүүлэх үүрэг бүхий төрийн байгууллагуудад хүргүүлсэн ба хэрэгжилтийг тооцон төлөвлөгөөний биелэлт, хэрэгжүүлсэн ажлын тайланг АТГ-т тогтоосон хугацаанд хүргүүлж, www.erdenet.mn сайтад байршуулж тайлагнаж байна. Аймгийн Засаг даргын дэргэдэх харьяа хэлтэс агентлаг, албадын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагаа, төлөвлөлт, ил тод байдалд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, зөвлөгөө мэдээллээр хангах ажлыг зохион байгуулсан. Төрийн албан хаагчдад зориулсан Авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг 3 байгууллагад явуулж нийт 116 албан хаагч хамрагдсан. АТГ-аас ирүүлсэн 2 Зөвлөмжийг хэрэгжүүлж тайланг хүргүүлсэн.	
5.2	Нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээн авах, хянах, бүртгэх ажлыг зохион байгуулах	-	ХАСУМ болон ХАСХОМ гаргасан албан тушаалтны тоо -хуулийн хугацаанд мэдүүлсэн байх	206	201	Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах 2024 оны ХАСХОМ-ыг шинэчлэн мэдүүлэх аймгийн Засаг даргын Тамгын газар болон Засаг даргаас томилогддог төрийн захиргааны албан тушаалтнуудын жагсаалтыг 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар гарган Авлигатай тэмцэх газарт тогтоосон хугацаанд хүргүүлсэн. Нийт 123 албан тушаалтан 2024 оны хөрөнгө орлогоо шинэчилж мэдүүлэхээс 123 албан тушаалтан хуулийн хугацаанд бүрэн мэдүүлсэн. Мөн 2025 онд шинээр томилогдсон 11 албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг томилогдохоос өмнө хянуулж, 10 албан тушаалтны ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд хүлээн авч хянан баталгаажуулаад байна. Салбар 8 байгууллагын эрх бүхий албан тушаалтнуудыг удирдлага, арга зүйгээр хангаж ажилласан. Хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээн авах, бүртгэхтэй холбоотой зөрчил, гомдол гараагүй болно.	100
6	Зорилт 6. “Хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг хангах, удирдлага, арга зүй, бусад дэмжлэг үзүүлэх” зорилтын хүрээнд:						
6.1	Хууль зүйн сайд аймгийн Засаг даргын 2025 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг хангах	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	55	65	Хууль зүйн сайд Орхон аймгийн Засаг даргатай 2025 онд хамтран ажиллах гэрээний биелэлтийг хангах ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж биелэлтийг явцын талаар улирал тутам хэлэлцэж, шаардлагатай арга хэмжээг авч гэрээний биелэлтийг ХЗДХЯ-нд тогтоосон хугацаанд хүргүүлсэн. Гэрээг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг орон нутгийн төсөвт тусгуулж батлуулах, тендер шалгаруулахад шаардлагатай төсөв тооцоо, техникийн үзүүлэлтүүдийг бэлтгэж хүргүүлэх, тендерээр гүйцэтгэж байгаа ажилд хяналт тавих ажлыг хэрэгжүүлж, шаардлагатай нөхцөлд холбогдох арга хэмжээг авч ажиллаж байгаа бөгөөд гэрээний хэрэгжилт 87.1 хувьтай байна.	100
6.2	Хуулийн байгууллагуудын үйл ажиллагаанд		Үйл ажиллагаа явуулах	-	Шаардлагатай дэмжлэг	Хуулийн байгууллагуудын үйл ажиллагааг бэхжүүлэх, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд 2025 онд орон нутгийн төсвөөс Цагдаагийн газрын дээвэр, гадна фасадны засвар, гэрэлтүүлгийн ажилд	100

	шаардлагатай дэмжлэг үзүүлэх		нөхцөлийг бүрдүүлэх		г үзүүлсэн байна.	109.5 сая төгрөг, энгэрийн камер, сүлжээний тоног төхөөрөмж худалдан авахад 350.0 сая төгрөг, олон нийтийн цагдаагийн ажилтны цалин, НДШ-ийн зардалд 390.0 сая төгрөг, Хөдөлгөөнт эргүүлийн машины шатахууны зардалд 20.0 сая төгрөг, Шүүх шинжилгээний хэлтсийн өрөөнүүдэд хэсэгчлэн засвар хийх ажилд 143.5 сая төгрөг, ШШХ-т хөлийн мөр илрүүлж, бэхжүүлэх иж бүрдэл, парафин цутгах аппарат худалдан авахад 52.5 сая төгрөг, Хорих ангийн дээврийн засвар хийхэд шаардлагатай материал худалдан авахад 111.8 сая төгрөг, Улсын бүртгэлийн хэлтэст иргэний бүртгэлийн болон хуулийн этгээдийн бүртгэлийн архивыг цахимжуулах гэрээт ажилтны цалин, НДШ-ийн зардалд 54.0 сая төгрөг, Төрийн архивт шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангаж ажиллах нөхцөлийг сайжруулахад 30.4 сая төгрөг, цахимжуулалт хариуцсан гэрээт ажилтны цалин, НДШ-ийн зардалд 57.0 сая төгрөг НИЙТ 1,318.7 сая төгрөг тусган батлуулж, зарцуулан ажиллаж байна. Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-437 дугаар нээлттэй хорих ангийн дарга 2025 онд шинээр томилогдож ирсэнтэй холбоотой Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 288 дугаар зүйлийн 288.5 дахь хэсэгт заасны дагуу Баян-Өндөр сум, Оюут баг 2А хороолол Гранд гарден хотхонд шинээр ашиглалтад орсон 2 өрөө орон сууцаар хангасан.	
6.3	Ял эдэлж буй иргэдийг хөдөлмөрлөх нөхцөлөөр хангах, ШШГГ-ын үйлдвэрлэлийн хэсэгт тоног төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах	112.0	Тоног төхөөрөмжөөр хангаж хөдөлмөр эрхлэх нөхцөлийг бүрдүүлэх	-	Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан байна. ШШГГ-ын хорих ангийн дээврийн засвар, гадна пасад болон цагдан хорих байрны хорих өрөөнүүдэд засвар, үйлчилгээ хийх хоригдол, хоригдогч нарын орчин нөхцөлийг сайжруулах ажлын хүрээнд барилга, засварын үйл ажиллагаанд шаардлагатай бараа, материал худалдан авахад зарцуулагдах 111.8 сая төгрөгийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэж, бараа материал авах гэрээний дагуу хорих ангийн дээврийн засвар, хорих өрөөнүүдийн засварын нийт 38 нэр төлийн бараа, материалыг бүрэн хүлээн авч акт үйлдсэн. Дээврийн засвар, гадна пассадны ажлын гүйцэтгэл 80 хувьтай. Цаашид хорих өрөөнүүдийн засварыг хийхээр төлөвлөн ажиллаж байна. 2025 оны эхний хагас жилийн байдлаар тус ангид хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээ авагдсан өсвөр насны 9 этгээд, насанд хүрсэн 1 этгээд хяналтад байна. Шүүхээс хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээ авагдсан насанд хүрсэн этгээдийг Орхон Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвтэй хамтран гагнуурчин мэргэжлээр суралцуулж гэрчилгээ олгон хувийн хэрэгт хавсаргасан. Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газраас мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн сургалтад механикжсан тээврийн хэрэгсэл механизмын завсар үйлчилгээ мэргэжлээр 2, хүнд механизмын тосолгоочин мэргэжлээр 1, барилгын цахилгаанчин мэргэжлээр 1 нийт өсвөр насны 4 этгээдийг хамруулж, гэрчилгээ олгосон.	100	

6.4	Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн үйл ажиллагааг сайжруулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	50,0	Ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байх	-	Тоног төхөөрөмжөөр хангагдсан байна	Орхон аймгийн Политехникийн коллежид 3 этгээд суралцаж байна. Мэдээлэл шуурхай удирдлагын төвд шаардлагатай техник, тоног төхөөрөмж худалдан авах ажлын зардалд орон нутгийн төсвөөс 476.0 сая батлагдсан. Үүний дагуу Дахуа брэндийн AI-д суурилсан Smart City системийг хэрэглээнд нэвтрүүлэх ажлын хүрээнд шаардлагатай сервер тоног төхөөрөмжийг худалдан авч ажиллагаанд оруулсан. Одоогоор 235 хяналтын камерт ухаалаг программ суурилуулаад байна. Энэхүү систем нэвтэрснээр хүний гадна төрх болон царайгаар, автомашиныг зөвхөн дугаараар бус өнгө хэлбэр хэмжээгээр хайх, явсан замын маршрут гаргах гэх мэт давуу талуудтай болсон. Системийн хэвийн найдвартай ажиллагааг хангах үүднээс 100кВА хүчин чадал бүхий UPS тог баригч системийг авч ашиглахаар тендер зарласнаар шалгарсан Прожект девелопмент тотал солюшн ХХК нь тоног төхөөрөмжийн суурилуулалтын ажлыг гүйцэтгэж байна. Мөн хотын төвийн уулзварын гэрлэн дохиог автоматжуулах алсын удирдлагад шилжүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу техникийн даалгаврыг боловсруулж, тендер зарлан гэрээний шатанд явж байна	100
-----	---	------	-----------------------------------	---	-------------------------------------	---	-----

Төлөвлөгөөг үнэлсэн:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА

Тэмдэг



Төсвийн шууд захирагч

Б.ГАНЗОРИГ

(огноо)

2025.06.12

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА

Нэгжийн дарга

Ж.БААСАНСҮРЭН

(огноо)

Тайлагнасан:
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА

(огноо)

Нэгжийн дарга
М.МӨНХБАЯР